

“МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ӨРСӨЛДӨӨН, ҮНЭ ТАРИФЫН ТАЛААРХ БОДЛОГЫН БАРИМТЛАХ  
ЧИГЛЭЛ”-ИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН  
ХЭСГИЙН ХИЙСЭН СУДАЛГАА

УЛААНБААТАР

2017 ОН

# НЭГ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРСӨЛДӨӨН, ҮНЭ ТАРИФЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ нь бүхэлдээ тоон технологид шилжиж, технологи, үйлчилгээний нэгдэн нийлэлт, интернетийн хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан салбарын эдийн засгийн үр ашигтай байдал, тогтвортой хөгжлийг хангах үүднээс үнэ тарифын зохицуулалт болон өрсөлдөөний бодлогыг дэлхий чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх шаардлага тулгараад байна.

## **1. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ӨРСӨЛДӨӨН, ҮНЭ ТАРИФЫН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Харилцаа холбооны салбарын өрсөлдөөн, үнэ тарифын бодлого, зохицуулалт нь Харилцаа холбооны тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд боловсруулагдан мөрдөгдөж ирсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээлэл харилцаа холбооны салбарын үйлчилгээний үнэ тариф тогтоох аргачлалыг батлах, тухайн зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тодорхойлогдсон үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний үнийг хянаж, зохицуулалт хийж байна.

1. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл. *Зохицуулах хорооны бүрэн эрх, 9.1.5 “харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах”; 9.1.6.”харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх;*
2. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйл. *Давамгайл байдлаа хууль бусаар ашиглах хэсгийн 7.1.2 “бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох”, 7.1.4 “бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан гаргах зорилгоор бараа бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр борлуулах”;*
3. Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйл. *“Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох хэсгийн 13.2.4 “бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн”;*
4. Өрсөлдөөний тухай хуулийн 6.3. *Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй. /Энэ хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/*

## **2. ҮНЭ ТАРИФ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХАМАРЧ БУЙ ХҮРЭЭ**

Харилцаа холбооны зохицуулах хорооны Зах зээл, үнэ тарифын үнэлгээ судалгааны газраас хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд дараах зохицуулалтыг хийж ажилладаг болно. Одоогоор тухайн зах зээлд зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгж болон давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд **ЗОХИЦУУЛАЛТТАЙ** байна.

## 2.1. ЗҮЙ ЁСНЫ МОНОПОЛЬ АЖ АХУЙН НЭГЖ

1. “ДДэшТВ” ХХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 06 тоот тогтоол*)

Телевиз радиогийн олон сувгийн үйлчилгээг хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээний зах зээл

2. "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГазар (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 12 тоот тогтоол*)

Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ байгуулах, түүнийг ашиглах үйлчилгээний зах зээл

3. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 20 тоот тогтоол*)

Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах, түүнийг эзэмших, ашиглах, худаг, сувагчлал түрээслүүлэх үйлчилгээний зах зээл

## 2.2. ДАВАМГАЙ БАЙДАЛТАЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

1. “Мобиком” ХХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 13 тоот тогтоол*)

Үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд

2. "Юнител" ХХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 13 тоот тогтоол*)

Үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд

3. “Монгол шуудан” ТӨХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2015 оны 17 тоот тогтоол*)

Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ зээлд

4. “Жемнет” ХХК (*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2012 оны 11 дүгээр тогтоол*)

Интернетийн /бөөний урсгал/ үйлчилгээний зах зээл

## 2.3. ЗОХИЦУУЛАЛТГҮЙ БАЙГАА ХЭСЭГ

Харилцаа холбооны зохицуулах хорооны Зах зээл, үнэ тарифын үнэлгээ судалгааны газраас хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тухайн зах зээлд зүй ёсны монополь

байдалтай аж ахуйн нэгж болон давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүдийн үндсэн үйлчилгээний үнэ тарифид зохицуулалт хийж байгаа бол бусад компаниуд ямар нэгэн үнэ тарифын **ЗОХИЦУУЛАЛТГҮЙ** байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх, 9.1.5 “харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах” гэсэн заалтын дагуу зөвхөн зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн эрхлэгчдийн үйлчилгээний тарифыг ХХЗХ-оос хянан зохицуулалт хийж байна.

Харин Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх 9.1.6.”харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх” заалтын дагуу ямар нэгэн шууд/эдийн засгийн/ зохицуулалтыг хийхгүй байна. Ингэснээр тухайн зах зээлд давамгайл байдалтай бус боловч өрсөлдөөнд шууд нөлөө үзүүлэх ялангуяа олигополь байдалтай зах зээлд эдийн засгийн зохицуулалтгүй байна. Энэ байдлыг Харилцаа холбооны зохицуулах байгууллагаас гаргасан тусгай зөвшөөрлийн ангиллын дагуу ангиллууд дээр авч үзье.

№	Зах зээл	Ангилал	Үйлчилгээ, бүтээгдэхүүн	Зохицуулалттай эсэх
			○ Худаг, Сувагчлал	<b>Зохицуулалттай</b>
			<b>Цөөн нийлүүлэгчтэй үйлчилгээ /Олигополь/</b>	
			○ Дэд бүтэц түрээслэх /байр, талбай, цамхаг, зай тэжээл /	<b>Зохицуулалт сул</b>
			○ Дамжуулах байгууламж түрээслэх /суваг, шөрмөс гэх мэт/	<b>Зохицуулалт сул</b>
			○ Өргөн зурвасын бөөний үйлчилгээ	<b>Зохицуулалт сул</b>

1	Өрсөлдөөн хязгаарлагдмал зах зээл	Мэдээлэл холбооны сүлжээ	<b>Монополь шинжтэй үйлчилгээ</b>	
---	-----------------------------------	--------------------------	-----------------------------------	--


ХХЗХ-ны зүгээс А ангиллын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй үйлчилгээ эрхлэгчдийн хувьд монополь шинжтэй үйлчилгээ эрхлэгч МХС ХХК-аас бусад үйлчилгээ эрхлэгчдийн үнэ тарифид зохицуулалт хийж чадахгүй байна. Гэтэл мэдээлэл холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулах байгууламж түрээслэх, өргөн зурвасын бөөний үйлчилгээнд зайлшгүй зохицуулалт хийх шаардлагатай байна.

№	Зах зээл	Ангилал	Үйлчилгээ, бүтээгдэхүүн	Зохицуулалттай эсэх
2	Өрсөлдөөнт зах зээл	Мэдээлэл холбооны үйлчилгээ	<b>Монополь шинжтэй үйлчилгээ</b>	
			○ Харилцан холболт	<b>Зохицуулалттай</b>
			○ Сүлжээнд холбогдох	
			<b>Цөөн нийлүүлэгчтэй үйлчилгээ /Олигополь/</b>	
			○ Яриа, өгөгдөл	<b>Зохицуулалт сул</b>
			○ Өргөн зурвасын үйлчилгээ	<b>Зохицуулалт сул</b>
			<b>Олон нийлүүлэгчтэй үйлчилгээ /өрсөлдөөнт/</b>	
		○ Интернет, өгөгдөл (ISP)	<b>Зохицуулалтгүй</b>	
		Өргөн нэвтрүүлэг	○ ТВ, суваг, радио	<b>Зохицуулалтгүй</b>
			○ Олон суваг дамжуулах	<b>Зохицуулалт сул</b>
Шуудан	○ Буухиа шуудан ○ Илгээлт ○ Логистик	<b>Зохицуулалтгүй /Монгол Шуудан ХК-аас өөр зохицуулалт байхгүй/</b>		

### 3. САЛБАРЫН ҮНЭ ТАРИФЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

#### 3.1. ҮНЭ ТАРИФ

Харилцаа холбооны зохицуулах хорооноос үнэ тариф өрсөлдөөний чиглэлээр ажиллахдаа тухайн салбарт давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үнэ тарифид зохицуулалт хийх замаар ажиллаж байсан. Давамгайл үйлчилгээ эрхлэгчийн үнэ тарифид шал үнэ тогтоосноор зах зээлд сүүлд нэвтэрсэн аж ахуйн нэгжүүдийг хөл дээрээ тогтох боломж олгосон. Мөн 2005 оноос үүрэн холбооны зах зээлийг либералчилснаар хэрэглэгчид үйлчлэх үйлчилгээний төрөл нэмэгдэж чанар сайжирч үнэ тариф эрс хямдарсан болохыг доорх графикаас харж болно.



Өөрөөр хэлбэл 2007 оноос үнэ тарифын зөрүү багасч нэг төвшин рүү явж байна. Харин 2014 оноос Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөмжүүд, олон улсын харилцаа холбооны хөгжлийн хандлага болон Монгол Улсын үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид тухайн зах зээлд өөрийн үндсэн үйлчилгээний үнэ тарифыг тогтоохдоо яриа, өгөгдөл, богино үсэгт мэдээ (цаашид SMS гэх) хосолсон багц хэлбэрт шилжүүлэх болсон. Үүнээс улбаалаад үүрэн холбооны үйлчилгээний үнэ тарифын 1 минутын төлбөрийг тодорхойлох хүндрэлтэй болсон бөгөөд үйлчилгээ эрхлэгчид сүлжээндээ хязгааргүй ярих үйлчилгээг өргөн нэвтрүүлэх болсон.

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээн доторх ярианы үйлчилгээний үнэ тариф тасралтгүй буурч байна. Дараа төлбөрт болон урьдчилсан төлбөрт үйлчилгээний хувьд сүлжээндээ хязгааргүй ярих багцуудыг санал болгож байгаа нь тариф буурах нөхцөл болж байна. Тарифын шинжилгээг 2009 – 2014 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамааруулан судалж үзэхэд дараах регрессийн тэгшитгэл гарсан.

$$\tilde{y} = 57.6 - 2.13x_1 + 0.001x_2 + 16.9x_3 \quad (R^2 = 0.78)$$

Энд:

$\tilde{y}$  – ярианы тариф

$x_1$  – инфляци

$x_2$  – долларын ханш

$x_3$  – салбарын хөрөнгө оруулалтын өсөлт

Дээрх судалгаанаас харахад салбарын хөрөнгө оруулалтын өсөлт нэг пунктээр нэмэгдэхэд тариф дунджаар 17 төгрөгөөр, долларын ханш нэг төгрөгөөр өсөхөд тариф

дунджаар 0.001 төгрөгөөр өсөж байгаа бол инфляцийг 1 нэгжээр бууруулахад тариф дундажаар 2 төгрөгөөр өсөх боломжтой байна.

Нийт хэрэглэгчийн дундаж орлого харьцангуй тогтвортой байгаа боловч орлогыг ам. Долларт шилжүүлсэнээр 30-40% бууралттай байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь үнэ тарифын зохицуулалт хийхдээ уламжлалт аргаар буюу үүрэн холбооны салбарт давамгайл үйлчилгээ эрхлэгчийн зөвхөн 1 минутын ярианы тарифын доод үнийг тогтоон барих аргаар хийж байгаа нь үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид үйлчилгээний тарифаа багцад шилжүүлсэн өнөөгийн цаг үед ихээхэн маргаан бэрхшээл дагуулж байгаа юм.

Иймд үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үйлчилгээний 1 минутын үнэ тарифид хяналт тавихаас илүүтэйгээр хэрэглэгчид санал болгож буй багцын үйлчилгээнүүд, багцын үйлчилгээний орц буюу багцад хамрагдаж буй үйлчилгээний нэр төрлүүдийг оновчтой зөв тодорхойлох, багцын орцод нэрлэгдэж буй тухайн үйлчилгээний амлалтыг хэрхэн тооцоолох, салбарын эдийн засгийн үр ашгийг хадгалж байх үүднээс үйлчилгээ эрхлэгчийн 1 хэрэглэгчээс олох орлого (ARPU)-ын хэмжээг тогтвортой байлгах, доод хэмжээг тодорхойлох боломжийг судлах, сүлжээндээ хязгааргүй ярих эрх олгох тарифын доод хэмжээг 1 хэрэглэгчээс олох орлого (ARPU)-той холбож тогтоох зэрэг олон зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэх нь илүү чухал юм.

Багц гэж юу вэ?

Дундаж хэрэглэгчийн хэрэглээнд тулгуурласан хэрэглэгчийн сар тутмын хэрэглээний хэмжээ юм.

Хоёроос дээш төрлийн бүтээгдэхүүний орцтой байна.

Ихэвчлэн яриа (тоо, хэмжээ), SMS, дата хэрэглээний тооцоогоор хэмжигддэг.

- ✓ Багц нь 2 төрөл байж болно. **Цэвэр** багц болон **Холимог** багц гэсэн төрөлтэй байж болно. Үүнд:



Тухайн орцын бүтээгдэхүүнүүдийг зөвхөн багц хэлбэрээр авч болдог. Ж: *Премиум мобайл үйлчилгээнүүд*



Тухайн орцын бүтээгдэхүүнүүдийг зөвхөн багц хэлбэрээр авч болдог. Ж: *Гурвалсан үйлчилгээ*

Үүрэн телефон холбооны хэрэглэгчийн тоо жил бүр өсөн нэмэгдэж, үүнийг дагаад үүрэн телефон холбооны сүлжээ доторх, гарах, орох ачааллууд тасралтгүй өссөөр байна. Доорх харахад үүрэн телефон холбооны ачаалаллууд 2008 оноос 2013 он хүртэл өсөлттэй байсан бөгөөд 2014 оны ачааллыг өмнөх оны мөн үеийн ачаалалттай харьцуулахад -0.06 хувиар сүлжээн доторх ачаалал, -0.21 хувиар үүрэн сүлжээнээс гарах ярианы ачаалал, -0.22 хувиар үүрэнд сүлжээнд орох ачаалал тус тус буурсан байна.

Цаашид үүрэн телефон холбооны ярианы ачаалал нь дата өгөгдөл рүү шилжих хандлагатай байна. Зах зээлийн өрсөлдөөн, технологийн хөгжил дэвшил гар утасны хэрэглээ, түүнийг дагасан нэмэлт үйлчилгээ болон контентууд ОТТ төрлийн үйлчилгээ нь хэрэглэгчийн тооны өсөлт, ашиг орлогод нөлөөлөхөөр байна.

Хэрэглэгчид улс хооронд болон дотоодод интернетэд суурилсан /wechat, viber, skype, kakao talk/-ийг г.м ашиглан үнэгүй ярьж байгаа нь ярианы ачаалал буурах хүчин зүйл болж байна.

### 3.2. ҮҮРЭН ТЕЛЕФОН ХОЛБООНЫ АЧААЛАЛ, ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ




Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн “Монгол Улсын мэдээлэл харилцаа холбооны салбарын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдалд шинжилгээ хийх, зах зээлийн суурь мэдээллийг бүрдүүлэх, судлах, шинжлэх тогтолцоог боловсронгуй болгох судалгаа”-ны дүнг харахад үүрэн холбооны ярианы ачаалал буурч өгөгдөлийн үйлчилгээ өсөн нэмэгдэж байгаа дүн статиктик тоо баримтаар батлагдан харагдаж байгаа юм.

Үүрэн телефон холбооны 2014 оны нийт орлогыг 5 жилийн өмнөх үетэй харьцуулахад 89,2 хувиар өмнөх онтой харьцуулахад 16.2 хувийн өсөлттэй байна.

Үүрэн телефон холбооны үйлчилгээний орлогын өсөлтөд хэрэглэгчийн тоо, хамрах хүрээ, хэрэглээний хандлага (дата хэрэглээ)-н шууд хамааралтай байна.




### Үүрэн телефон холбооны орлого/тэрбум.төг/



Үүрэн холбооны салбарын орлогын бүтцийг харвал хэдийгээр дата үйлчилгээний орлого өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа боловч нийт орлогод дөнгөж 13.16% эзэлж байна. Энэ нь үүрэн холбооны дата үйлчилгээний тариф харьцангуй хямд 3G болон 4G үйлчилгээний хэрэглээ харьцангуй бага байгааг харуулж байна.

### Үүрэн холбооны салбарын орлогын бүтэц



Үүрэн холбооны зах зээлд ярианы үйлчилгээний орлого давамгайлж байгаагийн дээр төлбөрийн нөхцлийн хувьд урьдчилсан төлбөрт хэрэглээ давамгайлж байгаа тул стандарт тариф буюу задгай хэрэглээг тооцох асуудлыг хэвээр хадгалах шаардлагатай байна.

#### 4. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ нь бүхэлдээ тоон технологид шилжиж, технологи, үйлчилгээний нэгдэн нийлэлт, интернетийн хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан салбарын эдийн засгийн үр ашигтай байдал, тогтвортой хөгжлийг хангах үүднээс үнэ тарифын зохицуулалт болон өрсөлдөөний бодлогод ихээхэн өөрчлөлт бий болох шаардлага тулгараад байна. Тус тусдаа хөгжиж ирсэн үйлчилгээнүүд нэгдэн нийлж байгаагаас өрсөлдөөний шинэ зарчмаар зохицуулах хэрэгтэй байна.

Өрсөлдөөнт зах зээлээс олигополь гэж үзэж байгаа зах зээлд эдийн засгийн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй гэж үзэж байна.

Тухайн зах зээл дээр **цөөн тооны, том хэмжээтэй** пүүсүүд давамгайлсан **нэгэн төрлийн**, эсвэл **ялгаатай** бүтээгдэхүүн үйлдвэрлэн оролцож байвал уг зах зээлийг **олигополь зах зээл** гэнэ. Уг зах зээл дээр үйл ажиллагаа явуулах пүүсүүдийн **тоо цөөн, хэмжээ нь харьцангуй том** учраас олигополь пүүс нь **үнэд нөлөөлөх боломж хүчтэй байдаг**. Тэд зах зээлийн хувь хэмжээг өсгөхийн тулд техник технологио шинэчилж зардлаа бууруулахаас гадна шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээр маш хүчтэй өрсөлддөг.

Иймд Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.6."харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх" заалтын дагуу тухайн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээр бус ҮНИЙН БУС өрсөлдөөнийг дэмжих тал дээр анхаарах шаардлагатай байна.

Үнийн өрсөлдөөнд орж үнээ хэт бууруулан өрсөлдөж байгаа компаниудыг хэрхэн зохицуулах вэ гэдэг нь **тулгарч буй асуудал болоод байна**.

Харилцаа холбооны зах зээл нь нэгдэн нийлэх процессоос улбаалан харилцаа холбооны олон төрлийн үйлчилгээ нь хоорондоо харилцан хамааралтай болсны зэрэгцээ хэрэглэгчийн сонголт, технологийн дэвшил зэрэг олон хүчин зүйлсүүдээс шалтгаалан төгс өрсөлдөөнт зах зээлээс аажмаар олигополь шинжтэй зах зээлийн хэлбэр рүү шилжиж байна.

Иймд зах зээл дээр зүй ёсны монополь болон давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгчдийн үнэ тарифид хяналт тавих зарчмаар тус салбарт эдийн засгийн үр ашигтай байдал, тогтвортой хөгжлийг хангах үндсэн зарчмыг хангалттай хэмжээнд зохицуулалт болж чадахгүй байна.

Тиймээс харилцаа холбооны зах зээл дээр шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх үндсэн эрх хэмжээний хүрээнд зөвхөн зүй ёсны монополь болон давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгчдийн үнэ тарифид хяналт зохицуулалт хийхээс гадна үнийн бус эдийн засгийн нарийвчилсан зохицуулалтуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.6. "Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх" заалтын хүрээнд харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, үйлчилгээний чанар, технологийн давуу байдал бий болгох боломжтой суурь үйлчилгээнүүдийн хувьд бодлогоор нэгдсэн зохицуулалт хийх, салбарын үр ашиг, тогтвортой хөгжлийг хангах нь цаашид баримтлах үндсэн зарчмуудын нэг гэж үзэж байна.

Мөн салбарын үр ашгийг хангах, үр ашигтай өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх үүднээс зах зээл дээр давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгчдээс гадна бусад үйлчилгээ эрхлэгчдийн үнийн хэт өрсөлдөөнд хяналт тавих нийтлэг зохицуулалтуудыг шат дараатай авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

#### 4.1 ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ

##### **А зөвшөөрөлтэй компаниудын санал**

- Засгийн газраас интернетийн бөөний урсгалын үнийг бууруулж 80000 төгрөгт хүргэх чиглэл өгсөн нь компанийн хувьд хүнд тусч байгаа,
- Засгийн газраас үнэ бууруулах шийдвэр гаргасан нь хувийн компаниудад хүндрэл үүсгэсэн,
- Үнэ бууруулах нь сүлжээний бизнес ашиггүй болгоно,
- Үнэ тарифыг хянах нь чухал.

##### **Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн санал**

- Шал үнийн бодлогын зохицуулалтыг хийх,
- ARPU-г өсгөх чиглэлээр зохицуулалт шаардлагатай,
- Салбарын үр өгөөж хөрөнгө оруулалтыг сайжруулах,
- Гаднаас орж ирж байгаа ярианы тарифыг өсгөх юм бол Монгол хэрэглэгчдэд нөлөөлөхгүй,
- Интернетийн бөөний үйлчилгээ хийдэг компаниуд давхар Retail хийж байна.

#### **ХОЁР. ОЛОН УЛСЫН ХОЛБОГДОХ ГЭРЭЭ, КОНВЕНЦИ, ӨРСӨЛДӨӨН, ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА**

Мэдээллийн технологи, харилцаа холбооны техник, технологи болоод үйлчилгээний нэгдэн нийлэлт эрчимтэй явагдаж, хөгжил эрс хурдасч байгаа үед энэхүү өөрчлөлтийг өсөлт, өрсөлдөх чадварын хүчин зүйл болгон салбарын эдийн засгийн өсөлтийг хурдасгахад дорвитой **хувь нэмэр оруулах асуудал чухал байна.**

МТХХ (ICT) гэх нэгдмэл салбар болон хөгжиж, хувь хүний болон бизнесийн гадаад орчны чухал хэсэг болоод байна.

МТХХ-ны хөгжлийн бодлого, зохицуулалт дахь томоохон өөрчлөлт нь өнөөгийн хөгжлийн ерөнхий хандлагыг өргөжүүлж бүтээгдэхүүн, үйлчилгээн дэх болоод үнийн өрсөлдөөн, үйлчилгээ эрхлэгч компаниудын бизнес загварын шинэчлэл, бизнесийн стратеги, маркетингид гарч байгаа өөрчлөлт, шинэчлэлт байна.

## 1. ОЛОН УЛСЫН ХОЛБОГДОХ ГЭРЭЭ, КОНВЕНЦИУД

№	Баримт бичиг	Хамрах хүрээ	Холбогдох заалтууд
1.	ОУЦХБ-ын үндсэн дүрэм, конвенц, 2014  Дагалдах протокол, шийдвэр, тогтоол, зөвлөмж	Үндсэн дүрэмд ОУЦХБ-ын зорилго, бүтэц, үйл ажиллагааны дүрэм, гишүүн орнуудын эрх үүрэг, Бүрэн эрхт төлөөлөгчдийн хурал, түүний дэг, Сонгууль болон холбогдох асуудлууд болоод Зөвлөл, Ерөнхий нарийн бичгийн дарга, Зохицуулах хороо, Радио холбоо, Цахилгаан холбоо, Цахилгаан холбооны хөгжил, стандарчлалын салбарууд, тэдгээрийн бүтэц, үйл ажиллагаа, ажлын журам, эдгээр 3 салбарын нийтлэг заалтууд, судалгааны бүлгийн үйл ажиллагаа, хурал чуулгантай холбогдох заалтууд, санхүү, хэл, төлбөр тооцооны зохицуулалт, мөнгөний нэгж, хөндлөнгийн шүүх зэрэг асуудлуудыг тусгасан байна.	Үнэ тарифын зохицуулалт талаар нарийн, тодорхой заасан зүйлгүй
2.	Олон улсын цахилгаан холбооны дүрэм		<p><b>43</b> 6.1.1 Each administration* shall, subject to applicable national law, establish the charges to be collected from its customers. The level of the charges is a national matter; however, in establishing these charges, administrations* should try to avoid too great a dissymmetry between the charges applicable in each direction of the same relation.</p> <p><b>44</b> 6.1.2 The charge levied by an administration* on customers for a particular communication should in principle be the same in a given relation, regardless of the route chosen by that administration*.\</p>
3.	RESOLUTION 55 (KYOTO, 1994) Use of the United Nations telecommunication network for the telecommunication traffic of the specialized agencies		resolves that the United Nations telecommunication network may carry the traffic of the specialized agencies which wish to use it, on condition that: 1 the specialized agencies pay for the telecommunication service on the basis of the cost of operation of the service by the United Nations and tariffs established by administrations within the framework of the Constitution and Convention (Geneva, 1992), Administrative Regulations and practices of the Union;
4.	RESOLUTION 101 (REV. BUSAN, 2014) Internet Protocol-based networks		h) Recommendation ITU-T D.50, on general tariff principles ´ principles applicable to international Internet connection;
5.	RESOLUTION 139 (REV. BUSAN, 2014) Use of telecommunications/information and communication technologies to bridge		mindful d) that, in many ITU Member States, independent regulatory bodies have been established to deal with regulatory issues such as interconnection, determination of tariffs, licensing and competition, designed to promote digital opportunities at the national level,

\* or recognized private operating agency(ies)

	the digital divide and build an inclusive information society		
6.	ITU-R ОУЦХБ-ын зохицуулалтын баримт бичиг	ОУЦХБ-ын бүтцийн нэгжүүд, гишүүн орнууд баримтлах	Үнэ тариф, өрсөлдөөнтэй холбогдох заалт байхгүй. Захиргааны болон бусад санхүүгийн үнэ, төлбөрийн асуудлууд байна.
7.	Дэлхийн радио холбооны дүрэм	Олон улсын радио давтамжийн зохицуулалт	Үнэ тарифтай холбоотой заалт байхгүй
8.	Цахилгаан холбоо компанийн ЗГ хоорондын гэрээ, 1995	Цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид, хэрэглэгчид	Хавсралт: МЦХ компанид олгосон лиценз 5. Харилцан холболт ба тоног төхөөрөмжийн хангалт 5.4.3 Нэмүү өртөгт үйлчилгээ эрхлэх бүх оператор, түүнчлэн видео буюу өгөгдөл дамжуулахад шаардагдах бусад мэдээллийн систем буюу кабелийн операторт ялгаваргүй хандана. Лиценз эзэмшигч нь үндсэн сүлжээнд холбогдсон бусад нийтийн цахилгаан холбооны систем болон зөвшөөрөл бүхий хувийн сүлжээнд шударга үнэ, тариф тогтоож аливаа ялгаваргүй хандана. 5.4.4.1 Харилцан холболтын үнэ тариф бүх тохиолдолд ялгаваргүй байх 6 Үнийн тодорхойлолт ба бүртгэл тооцоо 6.5 Үнийн дээд хязгаар 9. Шударга өрсөлдөөн 9.1-9.5
9.	Үүрэн холбооны операторуудын ЗГ хоорондын гэрээ		Баримт бичиг олдоогүй
10.	Япон-Монголын хэлэлцээр	Хоёр улсын хэлэлцээрт заасан үйл ажиллагаанд баримтлах. Цахилгаан холбооны үйлчилгээний худалдаанд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнд хамаарна.	Хавсралт 5 /7 дугаар бүлэг/ Цахилгаан холбооны үйлчилгээ 4 дүгээр зүйл Өрсөлдөөнийг дэмжих хамгаалалт  1. Тал бүр голлох үйлчилгээ үзүүлэгчийг дангаар, эсхүл хамтран өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа явуулах, эсхүл ийм үйлдлийг үргэлжлүүлэхээс хамгаалах зорилгоор зохих арга хэмжээг батлах буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.  2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд дараахь байдал хамаарна. Үүнд: (а) өрсөлдөөнийг хязгаарлахад харилцан татаас олгох үйлдэл хийх;  (b) өрсөлдөгчөөсөө олж авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг үр дүнд хүрэх зорилгоор ашиглах;

			<p>(с) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг бусад үйлчилгээ үзүүлэгчдэд үндсэн байгууламжтай холбоотой техникийн мэдээлэл болон тэдгээрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай арилжааны зохих мэдээллийг цаг тухайд нь өгөхгүй байх.</p> <p>6 дугаар зүйл Харилцан холболт</p> <p>2. Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт нь байгаа үндсэн дэд бүтцийг хянаж буй голлох үйлчилгээ үзүүлэгчийг техникийн хувьд боломжтой сүлжээний цэгт харилцан холболт хийх нөхцөлийг хангана. Уг харилцан холболтыг дараахь нөхцөлөөр хангана:</p> <p>(а) үл ялгаварлах нөхцөл, болзол (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) болон үнэ тариф;</p> <p>(b) дээр дурдсан голлох үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн ижил төрлийн үйлчилгээнд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг харилцан хамааралгүй үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл түүний харъяа буюу бусад байгууллагын ижил төрлийн үйлчилгээнд олгох;</p> <p>(с) Харилцан холболтыг ил тод, бодит болон эдийн засгийн хувьд боломжтой, хангалттай нарийвчилсан <b>өртөгт суурилсан үнэ болон нөхцөл, болзол</b>оор (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) цаг тухайд нь хангаснаар нөгөө Талын цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдахгүй сүлжээний бүрдэл, эсхүл байгууламжтай холбоотой төлбөр төлөх шаардлагагүй;</p> <p>(d) хүсэлтийн дагуу, хэрэглэгчдийн дийлэнх хэсэг холбогддог сүлжээний төгсгөлийн цэгээс бусад төгсгөлийн цэгт шаардлагатай нэмэлт байгууламжийг суурилуулах зардлыг тусгасан үнээр холболт хийх.</p>
11.	Цахилгаан холбооны харилцан холболт, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл /2016.05.23 А67/	1.1.Энэхүү баримт бичгээр Монгол Улсад цахилгаан холбооны дамжуулах үйлчилгээ эрхлэхэд баримтлах бодлогын чиглэл ба түүний зохицуулалтын зарчмуудыг тодорхойлно.	3.1. Голлох үйлчилгээ эрхлэгчид нь дангаар болон хамтдаа өрсөлдөөнийг хязгаарласан дараах үйл ажиллагааг явуулахгүй: 3.1.1 өрсөлдөөнийг хязгаарласан харилцан татаас олгох үйлдэл хийх; 3.1.2 өрсөлдөгчөөсөө олж авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг үр дүнд хүрэх зорилгоор ашиглах

		<p>3.1.3 бусад нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ эзэмшигч эсвэл үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилгээгээ үзүүлэхэд шаардлагатай үндсэн сүлжээний талаарх техникийн болон арилжааны зохих мэдээллээр цаг тухайд нь хангахгүй байх;</p> <p>4.1 Нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ эзэмшигч болон үйлчилгээ эрхлэгч нь бусад үйлчилгээ эрхлэгчдийн дахин борлуулах үйлчилгээнд үндэлсэлгүй эсхүл ялгавартай нөхцөл тавих буюу хязгаарлалт хийхгүй.</p> <p>5.1 Үндсэн сүлжээ эзэмшигч голлох үйлчилгээ эрхлэгч нь нь техникийн хувьд боломжтой сүлжээний цэгт харилцан холболтыг заавал хийнэ. Уг харилцан холболт нь дараах нөхцөлүүдийг хангана:</p> <p>5.1.1 үл ялгаварлах нөхцөл, болзол (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) болон үнэ тарифтай;</p> <p>5.1.2 дээр дурдсан голлох үйлчилгээ эрхлэгчийн өөрийн ижил төрлийн үйлчилгээнд олгодгоос дутуугүй чанарыг харилцан хамааралгүй үйлчилгээ эрхлэгчийн, эсхүл түүний харьяа буюу бусад байгууллагын ижил төрлийн үйлчилгээнд олгох;</p> <p>5.1.3 цаг тухайд нь харилцан холболтыг хийх ба уг харилцан холболт нь ил тод, бодитой болон эдийн засгийн бололцоог тооцсон нөхцөл, болзолтой (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) ба цахилгаан холбооны дамжуулах сүлжээ эсхүл үйлчилгээ эрхлэгч нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдахгүй сүлжээний бүрдэл эсхүл байгууламжид төлбөр төлөх шаардлагагүй хэмжээнд хүртэл хэсэгчилсэн, өртөгт суурилсан үнэ тарифтай байна;</p> <p>5.1.4 дийлэнх хэрэглэгчдэд санал болгодог сүлжээний төгсгөлийн цэгүүдээс өөр цэгт харилцан холболт хийх хүсэлт ирүүлсэн тохиолдолд нэмж сүлжээ байгуулахад шаардагдах зардлыг харилцан холболтын төлбөрт нэмж тооцсоны үндсэн дээр уг харилцан холболтыг хийх;</p> <p>5.2 Голлох үйлчилгээ эрхлэгч нь харилцан холболт хийхтэй холбоотой журмуудыг олон нийтэд ил тод хүргэнэ.</p> <p>5.3 Голлох үйлчилгээ эрхлэгч нь харилцах холболтын гэрээ эсвэл жишиг саналыг олон нийтэд ил тод хүргэнэ.</p>
--	--	---

## **2. ӨРСӨЛДӨӨН, ҮНЭ ТАРИФ ТОГТООХ ТАЛААР ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА**

Харилцаа холбооны салбарын өрсөлдөөн, үнэ тарифын бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээ эрхлэгчдийг зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, хэрэглэгчдэд чанартай найдвартай үйлчилгээ үзүүлэх, технологийн дэвшил, тогтвортой хөгжлийг хангах үүднээс дараах олон улсын баримт бичиг зөвлөмж, аргачлалуудыг баримтлан ажиллаж ирсэн билээ.

Үүнд ОУЦХБ-ын шийдвэр, зөвлөмжүүд, Европын холбоо/EU/-ны “Холболт, харилцан холболтын удирдамж” АНДЭЗХАБ /АРЕС/-ын “Харилцан холболтын хамрах хүрээ”, ДХБ-ын “Суурь цахилгаан холбооны тухай гэрээ” /АВТ/, Үйлчилгээн дэх худалдаалалтын Ерөнхий хэлэлцээр /GATS/, “Зохицуулалтын тодорхойлолтын баримт бичиг” /Regulation Reference Paper/ зэрэг баримт бичгүүд болон бусад холбогдох зөвлөмж, аргачлалууд багтана.

### **2.1 ҮНДСЭН ЗАРЧИМ**

Өрсөлдөөн, үнэ тарифын талаарх олон улсын баримт бичгүүдийн хүрээнд дараах үндсэн зарчмуудыг баримталдаг. Үүнд:

1. Үл ялгаварлах /non discrimination/ зарчим-үйлчлэгчид нь хэрэглэгчид болон бусад үйлчилгээ эрхлэгчдэд техникийн болон үйлчилгээний үнэ тарифын ялгаваргүй нөхцөл, ижил тэгш нөхцөлийг санал болгож байх
2. Ил тод, нээлттэй байх /Transparency/ зарчим- Бодлого, зохицуулалтын шийдвэр гарахдаа ил тод, нээлттэй хэлэлцүүлэгдсэн байх, нээлттэй хэрэгжиж мөрдөгддөг байх, мөн үйлчилгээ эрхлэгчид бодлого зохицуулалтын шийдвэрийн хүрээнд гарсан шаардлагатай мэдээллүүдийг бусад үйлчилгээ эрхлэгчид болон хэрэглэгчдэд ил тод байлгах
3. Өртөгт баримжаалах /Cost orientation/- Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф нь өртөгт баримжаалсан буюу өртгөө ямагт нөхсөн байх зарчмыг баримтлах, бараа бүтээгдэхүүний үнийг бодит зардлаас доогуур үнээр тогтоохгүй байх
4. Тогтвортой хөгжлийг хангах /Sustainability/ харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф нь уг үйлчилгээний удаан хугацаанд оршин тогтнох, үр ашигтай байх байдлыг хангахад чиглэгдсэн байх
5. Технологиос хамааралгүй байх /Technology neutrality/- үнэ тарифын болон өрсөлдөөний аливаа бодлого зохицуулалт нь технологиос хамааралгүй байх, нэгдэн нийлж буй үйлчилгээний болон хэрэглээний хандлагад нийцүүлэх, технологийн хөгжилтэй зохицуулан хэрэгжүүлэх боломжтой байх.

Манай улсын хувьд өнөөгийн нөхцөлд нийцүүлэн салбарын хөрөнгө оруулалтын оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн урт хугацааны үр ашгийг хангах үүднээс дараах зарчмуудыг тодорхойлсон:



- мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөрөнгө оруулалтын оруулалтын үр өгөөжийг хангахад чиглэх,
- мэдээлэл, харилцаа холбооны салбарт үр ашигтай, тогтвортой өрсөлдөх орчныг бий болгох,
- төрөөс зах зээл, өрсөлдөөнд нөлөөлөх нөлөөлөл, зохицуулалтыг багасгах,
- үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн урт хугацааны үр ашгийг хангах,
- зах зээлд шинээр орж ирж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн гарааны нөхцлийг бууруулах,
- хэрэглэгч боломжит үнээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авах боломжийг нэмэгдүүлэх.

## 2.2. ҮНИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ХАНДЛАГУУД

Цахилгаан холбооны үнийн зохицуулалтыг хийдэг янз бүрийн хандлагууд байдаг. Эдгээрээс **үнийг ялгавартай тогтоох, ашгийн хэмжээг тогтоох** зохицуулалтын аргуудыг ашигладаг. **Үнийг ялгавартай тогтоох** аргыг ихэвчлэн нийгэм эдийн засгийн байдал нийгмийн амьжиргааны түвшинтэй уялдуулан хэрэглэдэг. Энэ арга нь цахилгаан холбооны сүлжээ засгийн газрын мэдэлд байгаа нөхцөлд илүү тохиромжтой. Тухайлбал энэ аргаар хэрэглэгчийн холболтын хураамж болон хотын доторхи ярианы үнийг өртгөөс доогуур тогтоож өгч болно.

**Ашгийн хэмжээг тогтоох** аргаар үнийн зохицуулалт хийхдээ юуны өмнө тухайн үйлчлэгчийн нийт орлогыг тооцоолсоны үндсэн дээр тарифт шингээх ашгийн хэмжээг тогтоож өгдөг. Энэ ашгийн хэмжээ нь ерөнхийдөө зах зээлийн санхүүгийн нөхцөл байдалд үндэслэх боловч тухайн үйлчлэгчийн үйлдвэрлэлийн онцлог тухайлбал үйлчлэгчийн хүлээх алдагдал, онцгой албан татвар зэргийг харгалзан үзнэ. Тухайн үйлчлэгчийн үйлчилгээ тус бүрийн тооцоолсон орлогоос үндэслэн зохицуулагч нь хууль журмын дагуу хүлээн зөвшөөрч болох шингээх ашгийн хамгийн бага хэмжээг тогтоон өгдөг.

## 2.3. ҮНЭ ТАРИФ ТОГТООХ АРГУУД

Энэ хэсэгт олон улсад үнэ тариф тогтоох олон аргууд байдагийн хамгийн түгээмэл ашигладаг аргуудыг авч үзсэн болно.

### 2.3.1. Үнийн хязгаар тогтоох арга

Үнийн хязгаар тогтоох арга нь үнийн зохицуулалт хийдэг нийтлэг гол арга юм. Үнийн хязгаар тогтоох аргаар тухайн өгөгдсөн жилд үйлчлэгчийн үйлчилгээний үнийг өсгөх хамгийн их зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлж болдог. Үнийн хязгаар тогтоохдоо зайлшгүй нэмэгдэх зардлуудын өсөлтийг авч үздэг. / Тухайлбал инфляци, орлогын татварын өсөлт гэх мэт/

Үнийн хязгаар тогтоох арга нь ашгийн хэмжээг тогтоох аргаас дараахь давуу талуудтай. Үүнд:

- Өндөр үр ашигтай ажиллах сонирхолыг бий болгодог
- Шууд зохицуулалтыг хийх боломжтой
- Үнийн хөшүүргийг бий болгодог

Зах зээлийн өрсөлдөөний байдалд зохицуулан өртгөөсөө доогуур тарифыг тогтоон тодорхой хугацааны дараа өртөгт нь хүргэх зорилго тавих, тухайн хугацааны дараа өртөгт нь хүргэх зорилго тавих, тухайн үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт тогтвортой байлгах зорилгоор тухайн үйлчилгээний тарифт шингээх ашгийн хэмжээг тогтоох бол үнийн хязгаар тогтоох аргаар тарифыг тогтоож болно.

### **2.3.2. Малгай үнийн арга**

Энэ аргын дагуу хэрэглэгчдийн зарим тодорхой хэсэгт хамаарах багц үйлчилгээнд ноогдох төлбөрийн дээд болон доод хязгаарыг оператор тогтооно.

Малгай үнийн аргыг хэрэгжүүлэх хэд хэдэн механизм байдаг.

- Хэрэглээ багатай хэрэглэгчийн зарцуулдаг төлбөрийн хэмжээг хянах
- Ярианы зарим төрөлд нийцүүлэн тогтоох (хот доторх ба хот хооронд харин улс хоорондын ярианд хамаарахгүй)

Малгай үнийн зарчим нь үнийг тогтоох аргын хувьд олон улсад хамгийн түгээмэл хэрэглэгддэг зарчим болно.

Малгай үнийн аргаар үнэ тогтоох нь дараахь давуу талуудтай. Үүнд:

- Энэ зарчмын хүрээнд үнэ тогтооход үндсэн сүлжээ эзэмшигч уян хатан байх боломжтой.
- Уян хатан байдал нь үнлсэн сүлжээ эзэмшигчид шаардлагатай орлогоо хадгалахын зэрэгцээ өрсөлдөөнд орох боломжтой болно.
- Үндсэн сүлжээ эзэмшигч өртөг зардлаа багасгаж эхлэх.

Малгай үнийн зарчмаар үнийг тогтоохын тулд дараах үндсэн зүйлийг шийдвэрлэх шаардлагатай болно. Үүнд:

- Хязгаарыг тогтоох үйлчилгээний төрлийг тодорхойлох,
- Эсвэл үнэмлэхүй нөхцөл тогтоох,
- Хэрэглэгчийн үнийн индексээс хамаарсан хэмжигдэхүүн байх эсэх,
- Хязгаар тогтоох хугацаа ямар байх.

Дэлхийн ихэнх орнуудад инфляцийн түвшинд тулгуурласан хязгаарыг тогтоодог.

### **2.3.3. Тариф тэнцвэржүүлэх арга**

Тарифыг тэнцвэржүүлэнэ гэдэг операторууд нь үйлчилгээний бодит өртгийг туслах зорилгоор тарифаа тохируулах арга зам юм.

Өрсөлдөөнт зах зээл нь үйлчилгээний үнэ тарифыг тэнцвэржүүлэхийг шаардаж эхэлдэг. Өөрөөр хэлбэл өрсөлдөөн нэвтэрснээр тарифыг тэнцвэржүүлэх явц эхэлнэ. Үүний тулд:

- Өрсөлдөгчийн өндөр байгаа үнийг тэнцвэржүүлэх зорилт тавина. Ялангуяа хот хооронд болон улс хоорондын үйлчилгээний үнэ эхний шатанд хамрагдана.
- Өрсөлдөөний явцад хэрэглэгчдээ алдахгүйн тулд үндсэн сүлжээ эзэмшигч үнээ зайлшгүй бууруулах болдог.

Зохицуулах байгууллага тариф тэнцвэржүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг байна. Тариф тэнцвэржээгүй тохиолдолд өрсөлдөгчдийн үйлчилгээ хязгаарлагдмал болох , үндсэн сүлжээ эзэмшигч бүх нийтийн үйлчилгээний үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг сөрөг үзэгдлүүд гарч болзошгүй тул балансжилтыг хурдан хийх шаардлагатай байдаг байна.

Тариф тэнцвэржүүлэх туршлагыг нэвтрүүлсэн орнуудад үйлчилгээний үнэ өртөгтөө дөхөж очсон байна.

#### **2.3.4. Үнийг хянах арга**

Зах зээлд давалгайлагч үйлчлэгч нь тарифыг тогтоохдоо шударга бус өрсөлдөөний нөхцөл бий болсон үед тарифын хяналтыг хэрэгжүүлэх хэрэгтэй болдог. Зах зээлд либеральчлал эхэлснээс хойших жилүүдэд шударга өрсөлдөөнийг тогтоох нь хүндрэлтэй асуудлын нэг байдаг учраас үнийн хяналт хийх мөн чанарыг тодорхойлж, ямар түвшинд үнийг хэрхэн тогтоосныг хянах шаардлагатай болдог байна.

Үнийг хяналтыг тогтоохын тулд:

- Үйлчлэгчийн хөрөнгө оруулалтын өгөөжийн нөхөн төлөлтийг хангах,
- Хүнд суртал дарамт шахалт учруулахгүй байх ,
- Үнийн хяналтын механизм нь иж бүрэн цогц байх,
- Үнийн хяналт ил тод байх,
- Хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн байх зарчмуудыг баримтлах шаардлагатай.

Үнийн хяналтыг давамгайлагч үйлчлэгчид тавих нь бусад үйлчлэгч нарт тодорхой үр нөлөөг үзүүлдэг. Тухайлбал давамгайлагчаас бусад үйлчлэгч нарын үнэ тариф нь ямагт давамгайлагчийн үнэ тарифаас доогуур байдаг учир нэг талаар цахилгаан холбооны салбарт тэр чигт нь нөлөөлдөг. Нөгөө талаар үнийн хяналт нь эдийн засагт шууд нөлөөлж байгаа учраас зохицуулагч нь өрсөлдөөнд ямар үр ашиг авчрах, хэрэглэгчдэд ямар ашиг авчрахыг иж бүрнээр нь авч үзэх хэрэгтэй болдог байна. Эцэст нь зохицуулагч нь үнийн хяналтыг хийхдээ хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хэрэгцээг хангахад чиглэх ёстой.

Олон улсын ба дотоодын үнийг дахин тэнцвэржүүлэхэд үнийн дээд хэмжээг зохицуулах хэрэгтэй. Олон улсад зайлшгүй шаардлага ба боломжит байдлыг хоёуланг нь үнийн түвшинг дахин тэнцвэржүүлэхэд ашиглаж байна.

Үнийн хязгаарлагдмал байдал нь операторын үнийн уян хатан, үр ашигтай байх чанарыг үгүй болгодоггүй тул олон улсын үнийн боломжит хувирал ба хэрэглэгчийн эргэлзээ зэргийг харгалзан үнийг дахин тэнцвэржүүлэхэд хамгийн багадаа үнийн дээд хэмжээтэйгээр төлөвлөн зохицуулах хэрэгтэй байдаг байна.

## ГУРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Харилцаа холбооны салбарт өнөөгийн байдлаар мөрдөгдөж байгаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд өрсөлдөөн, үнэ тарифын талаарх бодлого, зохицуулалтын баримт бичгүүдийн судалгаа хийсэн. Харилцаа холбооны зохицуулах хороо нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээлэл харилцаа холбооны салбарын үйлчилгээний үнэ тариф тогтоох аргачлалыг батлах, тухайн зах зээлд давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тодорхойлогдсон үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний үнийг хянаж, зохицуулалт хийж байна.

Түүнчлэн зохицуулалттай болоод зохицуулалтгүй байгаа үйлчилгээний нэр төрлөөр авч үзэхэд одоогоор тухайн зах зээлд зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгж болон давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд **ЗОХИЦУУЛАЛТТАЙ** байгаа бол бусад компаниуд ямар нэгэн үнэ тарифын **ЗОХИЦУУЛАЛТГҮЙ** байна.

Зохицуулалттай болон зохицуулалтгүй үйлчилгээний төрлийг Харилцаа холбооны зохицуулах байгууллагаас гаргасан тусгай зөвшөөрлийн ангиллын дагуу ангилал тус бүрт авч үзсэн. Эндээс үзэхэд Интернет, өгөгдөл (ISP), ТВ, радио, өргөн нэвтрүүлгийн сувгууд болон шуудангийн бүх төрлийн үйлчилгээ нь **ЗОХИЦУУЛАЛТГҮЙ** байна.

Судалгаанаас харахад харилцаа холбооны зах зээл нь нэгдэн нийлэх процессоос улбаалан харилцаа холбооны олон төрлийн үйлчилгээ нь хоорондоо харилцан хамааралтай болсны зэрэгцээ хэрэглэгчийн сонголт, технологийн дэвшил зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан төгс өрсөлдөөнт зах зээлээс аажмаар олигополь шинжтэй зах зээлийн хэлбэр рүү шилжих хандлагатай болсон.

Иймд зах зээл дээр зүй ёсны монополь болон давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгчдийн үнэ тарифид хяналт тавих зарчмаар тус салбарт эдийн засгийн үр ашигтай байдал, тогтвортой хөгжлийг хангах үндсэн зарчмыг хангалттай хэмжээнд зохицуулалт болж чадахгүй болсон тул цаашид дараах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- харилцаа холбооны салбарын техник технологийн хөгжил дэвшил, үйлчилгээний нэгдэн нийлэлт, бизнесийн орчинд нийцүүлэн “Монгол улсын Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тарифын талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг шинэчлэх,
- үйлчилгээ эрхлэгчдийн үнийн хэт өрсөлдөөнд хяналт тавих нийтлэг зохицуулалтуудын шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ҮНИЙН БУС өрсөлдөөнийг дэмжих боломжийг бүрдүүлэх.

## Судалгааг хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Батбаяр	Тус газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
Ажлын хэсгийн нарийн бичиг:	А.Уранчимэг	Тус газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Т.Ганбат	ХХЗХ-ны Зах зээл үнэ тарифын үнэлгээ, судалгааны газрын мэргэжилтэн
Гишүүд:	Б.Цэцэг	Тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн ХШДАА-ны ахлах мэргэжилтэн
	Б.Солонго	Тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	С.Онончимэг	Тус газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Эрдэнэбулган	ХХЗХ-ны Зах зээл үнэ тарифын үнэлгээ, судалгааны газрын дарга
	А.Лувсан-Очир	ХХЗХ-ны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга
	Х.Нинжболор	ХХЗХ-ны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын ахлах мэргэжилтэн
	Б.Байгалмаа	ХХЗХ-ны Зах зээл үнэ тарифын үнэлгээ, судалгааны газрын ахлах мэргэжилтэн
	Г.Мөнхтулга	ХХЗХ-ны Зах зээл үнэ тарифын үнэлгээ, судалгааны газрын мэргэжилтэн